



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№256 /465/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.01.30

Цаг үе, үйл явдал

УУХАЙ ХАДААСАН БҮСГҮЙЧҮҮД БАРИАНД ОРЖ ИРЭХ АГШИН ГОЁ...



мөнгөн медаль хүртэж зогссон тэрээр энэ өдрүүдэд ч бас гардан тулаан, цэрэгжлийн гимнастикийн цогцолбор тэмцээнд оролцоод завгүй яваа.

Ахмад Н.Ууганцэцэг нь 2007-2011 онд МУБИС-ийн Биеийн тамирын дээд сургуулийг биеийн тамирын багш, дасгалжуулагч мэргэжлээр төгсөж, 2005 оноос эхлэн цанын спортоор хичээллэж, 2007 онд цанын спортын дэд мастер, 2008 онд цанын спортын мастер, 2011 онд Олон улсын хэмжээний мастер цол тус тус хүртсэн тамирчин офицер.

Түүний сурагч болон оюутан байх үеийн амжилтаас товч дурдвал 2005 оны Өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хошой алтан медаль, 2007 онд Монголын хүүхдийн III их наадмаас 6 алтан медаль, 2008 онд Монголын бүх Ард түмний XI спартакиадын 1 алт, 1 хүрэл медаль, 2007 оны Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний 4 алтан медаль, Хөнгөн атлетикийн насанд хүрэгчдийн



улсын аварга шалгаруулах тэмцээний хүрэл медаль, 2005-2009 оны кроссын улсын аваргын алт, мөнгө, хүрэл медальтай. Мэдээж энэхүү амжилтаараа "Шилдэг сурагч" болон "Шилдэг оюутан"-аар шалгарч байж.

Цэрэгжлийн спортын тухайд 10 гаруй жил эрчимтэй хичээллэж, Зэвсэгт хүчний аварга шалгаруулах тэмцээн бүрт тасралтгүй оролцож, алт, мөнгө, хүрэл медалийг өнгө өнгөөр нь хүртсэн бүсгүй.

Зэвсэгт хүчний болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит "Марш-тусгай бэлтгэл"-ийн аварга шалгаруулах тэмцээн, Зэвсэгт хүчний зуны 5 төрөлтөөс түүсэн медалийн тоо мэдээж хязгааргүй санж.



Тэр бас 2018-2019 онд БНӨСУ-д энхийг сахиулах үүрэг гүйцэтгэж байхдаа уламжлал болгон зохион байгуулагддаг "Данкон" олон улсын цэргийн гүйлтийн тэмцээнд алт, мөнгө, ОХУ-д зохион байгуулагдсан "Олон улсын биатлон"-ы тэмцээнд хошой хүрэл медаль хүртсэн юм.

2009-2017 онд Монгол Улсын цанын шигшээ багийн тамирчин, 2007-2017 онд "Алдар" спорт хорооны цанын тамирчин явсан ахмадын төрсөн дүү Н.Жаргалсайхан мөн цанын спортоор хичээллэдэг офицер. Эгч дүүс хамтдаа Тавантолгой дахь их, бага хайрхны өврөөр салаа, тасагтайгаа буугаа үүрээд гүйж явахад нь аппарат тэврээд хүлээгээд л зогсож байсны хувьд ахмад Н.Ууганцэцэгийн шантаршгүй эрч хүч, дундаршгүй тэсвэр хатуужлаар нь бахархаж билээ. Уухай хадаасан бүсгүйчүүд барианд орж ирэх агшин нь бүүр л гоё сон.

Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн алдар түүхт дархлагдсан тамирчин бүсгүйчүүдийг залгамжлан гарч ирсэн цэрэгжлийн спортын шилдэг эмэгтэй тамирчдын нэг нь яахын аргагүй тэр мөн билээ. **Ахмад Д.БОЛОР**

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,495	3,502
EUR	3,810	3,825
CNY	517.50	520
RUB	48.50	48.80
JPY	27.00	27.30
KRW	2.85	2.87

ЗУРХАЙ

2023.01.30 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 9

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал: Өвчин өчүүхэн ирнэ Наран ургах, шингэх: 08.23-17.48 Барилдлага: Үхэх Шүтэн барилдлага: Авахуй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэглэн бүтнэ, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

УЛСЫН ХАРЦАГА, ДЭД АХЛАГЧ Б.ЗОРИГТБААТАР ТҮРҮҮЛЛЭЭ




Архангай аймгийн Цэнхэр сумын 100 жилийн ойд зориулсан "Эко констракшн" ХХК-ийн нэрэмжит Улс, аймгийн алдар цолтой 256 бөхийн барилдаанд "Алдар" спорт хорооны бөхчүүд өнгөтэй сайхан барилдлаа. Архангай аймгийн Батцэнгэл сумын харьяат, "Алдар" спорт хороо, "Бөхбилэгт" дэвжээний бөх, улсын үнэн зоригт харцага, дэд ахлагч Б.Зоригтбаатар түрүүлж, Архангай аймгийн Цэнхэр сумын харьяат, "Алдар" спорт хороо, "Бөхбилэгт" дэвжээний бөх, улсын гарди, дэд ахлагч М.Бадарч үзүүлэв.

Их шөвгийн дөрөвт Архангай аймгийн Булган сумын харьяат, "Алдар" спорт хороо, "Бөхбилэгт" дэвжээний бөх, улсын арслан, ахлах дэслэгч Р.Пүрэвдагва, Увс аймгийн Тэс сумын харьяат, "Хилчин" спорт хороо, "Увснуур" дэвжээний бөх, улсын начин Ж.Ням-Эрдэнэ нар шалгарлаа.

Дунд шөвгийн наймд улсын гарди Ө.Бат-Орших, улсын харцага, ахмад Б.Одгэрэл (Алдар спорт хороо), улсын начин Б.Түвшинтөгс, аймгийн арслан Н.Намансүрэн нар үлдлээ.

Дэд хурандаа Т.ӨСӨХ-ИРЭЭДҮЙ

ТУУХАЙ ӨРГӨЛТИЙН ТЭМЦЭЭН ТАНХИМ БОЛОН ЦАХИМААР АМЖИЛТТАЙ ЯВАГДАВ



Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах цогцолбор тэмцээн амжилттай үргэлжилсээр байна. Энэ сарын 26-ны өдрөөс эхэлсэн туухай өргөлтийн тэмцээний аваргууд тодорсон байна. Тэмцээнд Зэвсэгт хүчний 200 гаруй алба хаагч оролцсоноос Зэвсэгт хүчний 327, 331, 339, 340 дүгээр ангийн тамирчид цахим буюу шууд дамжуулалтаар дүнгэгдсэн юм. Энэ удаагийн туухай өргөлтийн тэмцээн эмэгтэй 3, эрэгтэй тамирчид 6 жингийн төрлөөр явагдсан бөгөөд эмэгтэй тамирчид анх удаа огцом өргөлтөөр өрсөлдсөнөөрөө онцлогтой байв.

Зэвсэгт хүчний 2023 оны туухай өргөлтийн аваргуудыг 1 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулагдах цогцолбор тэмцээний нээлтийн ёслолын үеэр зарлаж, шагналыг нь гардуулна.

Тэгвэл туухай өргөлтийг залгуулаад 1 дүгээр сарын 30, 31-ний өдрүүдэд гардан тулаан, 2 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд цэрэгжлийн гимнастикийн тэмцээн явагдана.

Тэмцээний нээлтийн ёслол 1 дүгээр сарын 30-ны өдөр, хаалтын ёслол 2 дугаар сарын 2-ны өдөр тус тус зохион байгуулагдахаар товлогджээ.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 674,890,907

Эдгэрсэн Нийт: 647,148,122

Нас барсан Нийт: 6,759,623

“ЖАГСААЛЫН ТОЛЬ НЬ АХЛАГЧ БИД БАЙХ ЁСТОЙ”



Өнөөдөр Зэвсэгт хүчний даргалах албан тушаалын ахлагч нарын цугларалт эхэлж байна. Зэвсэгт хүчний цөм болсон ахлагчийн албыг удирдах чиглүүлэх, үлгэрлэн манлайлах үүрэгтэй даргалах албан тушаалын ахлагч нарын төлөөлөл болж Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн ахлагч, тэргүүн ахлагч Ганхуягийн Алтанбаганын ажлын нэг өдрийг сурвалжиллаа.

Бүрэн дуутай эх орны өглөө. Эр цэргийн сүр хүч, золбоо хийморь тугтайгаа мандсан энэ өглөө улаан залаат их буучдыг үе үеэр нь “төрүүлсэн” алдар түүхт Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хашаагаар жавартай ханьсан орлоо. 08.00 цаг гэхэд артиллерчдын олонх нь цугласан байх агаад нийтлэлийн баатар тэргүүн ахлагч Г.Алтанбагана тэрнээс ч өмнө ирчихсэн гээд өрөөндөө сууж байв. Тэрээр энэ өдөр

хоёр ажил төлөвлөсний нэг нь ангийн бие бүрэлдэхүүндээ “Ахлагчийн өдөр”-тэй холбоотой уулзалт, нөгөөх нь ирэх даваа гаригт (өнөөдөр) явагдах цугларалтад хувийн бэлтгэл хангах гэнэ.

“Ахлагчийн өдөр”-ийг тус ангийн ахлагчаар 2022 оны 8 дугаар сард томилогдож ирснээсээ хойш анх удаа зохион байгуулах гэж буйгаа хамгийн эхэнд тодотгов. Түүний өгүүлснээр “Ахлагчийн албыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр 2022-2024”-өөр алба салбараа сурталчлах, албаны итгэл үнэмшлийг дээшлүүлэх, сургаж бэлтгэх, соён гэгээрүүлэхэд “Ахлагчийн өдөр”-ийг нэгтгэл, ангиуд сар бүр хэрэгжүүлж байхыг тусгажээ. Томилогдож ирснээсээ хойш хэрэгжүүлж амжилгүй явсаар 2023 оноос хэвшил болгох зорилт тавьж, анхны хурлаа хийхтэй таарсан нь энэ.

Хурлын танхимд бүрэлдэхүүн бэлэн суусны дараа тэрээр цаг үеийн мэдээлэл хүргэж, “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм” болон шинэчлэгдсэн “Цэргийн нийтлэг дүрэм”-ийг уншиж судлахыг захилаа. Цэргийн хүн хоёр зүйлээр ээсрэг ялгарах ёстой. Анхлан харьцахад л мэдрэгдэх зүйл. Нэгдүгээрт, цэрэгжилтээрээ. Энэ таны гадаад гоо үзэмж. Хоёрдугаарт, ёс суртахуунт байдлаараа. Энэ таны дотоод гоо үзэмж гэж ахлагч нартаа онцолж, ЗХЖШ, ХЗЦК-аас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийн талаар үргэлжлүүлэн ярилаа.

Тэргүүн ахлагч Г.Алтанбаганаас хурал цуглааны ажиллагаагаа дуусгасны дараа “Алба ажлын цаана амьдрал байдаг. Таны ахлагч нарынхаа төлөөх баримталдаг чанар” гэж асуухад “Ажилдаа эзэн байхыг нь л хүсдэг, шаарддаг. Үүрэг өгөхөд зөрүүдэлж, эсэргүүцэж, элдэв шалтаг тооцдог байдал цэргийн хүнд хэзээ ч байж болохгүй. Тэр утгаар нь ажил албандаа сэтгэл хангалуун, хамт олондоо эерэг нөлөөлөл үзүүлэгч байгаасай гэж хэлж ярина. Та асуулаа, баримталдаг чанарын тухай. Би ахлагч нарынхаа нас насанд тааруулж харилцахыг хичээдэг. Яагаад гэхээр хоёр өөр нийгэм, өөр цаг үед төрсөн хүмүүсийн сэтгэлгээ, хандлага харилцан адилгүй. Миний үе болон дээд үеийнхэн хэвшмэл ойлголттой, тэгж болно, болохгүй гэдэг бол орчин үеийнхэн нийгмээ дагаад янз бүр. Хэдий нэг журамтай цэргийн орчин ч гэсэн нийгмийн нэгэн салбарынх нь хувьд салгаж ойлгох аргагүй. Албан ёсоор үүрэгдэхээс гадна ахын ёсоор зөвлөх, анд нөхрийн ёсоор учирлах гээд олон арга барилаар ажилладаг гэх үү дээ” гэв.

Түүний өгүүлснээр Зэвсэгт хүчний 120 дугаар ангийнхан 2023 оны ажил, арга хэмжээгээ Зэвсэгт хүчнээс зарласан “Залуу офицеруудын манлайллын жил”-тэй уялдуулж, зохион байгуулж байгаа гэнэ. Залуу офицер, ахлагч нарынхаа манлайллыг дээшлүүлэх хүрээнд “Сургалт бэлтгэл, инновац”, “Цэргийн алба, биеийн тамир”, “Соёл урлаг, уран сайхан”, “Нийгмийн хамгаалал”, “Бүтээлч ажил” гэсэн таван бүлэгт хуваарилан, манлайллыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Ингэхдээ “Өөрсдөөр нь” гэсэн зарчмаар бусдыгаа үлгэрлэхэд алба хаагч бүрээс идэвх оролцоо,

хичээл зүтгэлийг нь шаардах ажээ.

Тэр бас залуустаа “Цэргийн хүн болохоор шийдэж тангараг өргөсөн л бол энэ албанаас ухрах, урвах ямар ч шалтгаан байж болохгүй. Цэргийн тангараг өргөхдөө бид ингэж амласан юм. Түрхэн зуурын зовлон бэрхшээл, хямралыг давах сэтгэлийн хат, хүмүүжил мөрдөстэй хэн бүхэнд заавал байх ёстой. Ажиллаж хөдөлмөрлөхгүйгээр хүслээр хүрээд ирдэг, бэлнээр ороод ирдэг зүйл гэж энэ хорвоод үгүй. Хариуцсан ажилдаа сэтгэл зүрхээ өгч, махран зүтгэдэг хүмүүсийг би хувьдаа хүндэтгэж хайрладаг” гэв.

Биднийг ийн ярилцах зуурт тус ангийн ажиллагааны ахлагч, сургагч ахлагч Ч.Лхагважав тодорхой чиглэлээр ярилцаж, үүрэг аваад гарлаа. Тэргүүн ахлагчид дэмжлэг үзүүлдэг ахлагчийн нэг нь тэр бөгөөд мөн дивизионы ахлагч, сургагч ахлагч Д.Дагважамц, ахлах ахлагч Э.Буянбаатар, ахлах ахлагч Ц.Эрдэнэхуяг нар гэнэ. Артиллерчдын олонхийг бүрдүүлдэг залуусынхаа үүрэг гүйцэтгэлт болон тэдний санал хүсэлт, тавьж буй шаардлагынх нь талаар үнэн зөв бодитой мэдээллийг ангийн удирдлагадаа танилцуулах нь миний үүрэг гээд “Манайд жагсаалын толь нь болсон олон сайхан ахлагч бий” гэж магтав.

Түүний төгссөн сургууль, эзэмшсэн боловсрол, гэр бүлийнх нь тухай яриагаар үргэлжлүүлэв. Тэрээр 2000-2001 онд БХИС-ийн харьяа Ахлагч бэлтгэх төвд зэвсгийн нярав мэргэжлээр суралцан төгсөж, ажлын гараагаа Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн Дундговь аймаг дахь тусгай салбараас эхлүүлжээ. Үүний дараа “Цэргийн хүн тушаалаар” гэдэгчлэн Зэвсэгт хүчний 015 дугаар ангид харуулын дарга, салааны захирагчийн орлогч, ҮБХИС-ийн Ахлагчийн сургуульд сургагч багш, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлагч, өнгөрсөн оны 8 дугаар сараас Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн ахлагчаар тус тус томилогдож. Туулсан замаа эргэж хархдаа таван анги, байгууллагад томилогдож, говийн бүсэд, баруун алтайд, сургалтын байгууллагад, төвийн бүсэд ажиллаж, тэр бүртээ суралцсандаа бахархаж явдаг гэнэ.

Мөн 2017 онд Зэвсэгт хүчний Жанжин штабын тушаалаар Сургалтын хөдөлгөөнт бүлэг байгуулагдаж,

Ховдод баруун аймгийн Зэвсэгт хүчний ангиудын ахлагч нарын бүсчилсэн сургалтыг зохион байгуулахад оролцсондоо талархдаг, бүлгийг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн ахлагч, тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр ахалж байсан гэлээ. Тэрээр надад урам зориг хайрлаж, итгэл хүлээлгэсэн олон сайхан цэргийн дарга нарын нэг нь Д.Мөнхбаяр тэргүүн гэж нэмж тодотгов.


Тэргүүн ахлагч маань алба хааж буй 23 жилийн хугацаанд 2007, 2010 онуудад Сьерра Леон болон Чад улсад энхийг сахиулах үүрэг гүйцэтгэж, 2008-2012 онд “Цэцээ гүн” дээд сургуульд төрийн захиргаа, удирдлагын менежер мэргэжлээр суралцаж, 2013 онд ҮБХИС-ийн штабын ахлагчийн дамжаа, 2016 онд ҮБХИС-ийн рот, батарейны ахлагчийн дамжаа, 2018 онд Батлан хамгаалах Удирдлагын академийн “Ахлагчийн дээд дамжаа”-г тус тус дүүргэжээ.

Тэр эхнэр, хүү, аавынхаа хамт амьдардаг. Түүний аав Д.Ганхуяг насаараа Зэвсэгт хүчиндээ алба хаасан бэлтгэл офицер бөгөөд 2003 онд тэтгэвэртээ гарсан буурал. Аавынхаа мэргэжлийг өвлөж зэвсгийн нярав болсон нь амьдралынх нь зөв сонголтуудын нэг байсныг тэр бахдам өгүүлэх. Харин эхнэр О.Ариунзаяа багш мэргэжилтэй, өдгөө Ерөнхий боловсролын “Атланта” дунд сургуулийн захирал, хүү А.Хангал “Эрдмийн Ундраа” цогцолбор сургуулийн 11 дүгээр ангийн сурагч. Ажил албандаа тавьсан олон зорилгоос гадна хүний ганц үрийн хувьд аавыгаа ачилж хайрлах, хүүгээ зөв төлөвшүүлж хүмүүжүүлэх эцгийн үүргийн талаар ч тэр бас сайхан дурсамж ярилаа.

Ийнхүү бид ахлагчийн алба, ахуй амьдрал, зорилго төлөвлөгөө гэж ярилцсаар хэдийн хоёр цаг өнгөрсөн байх бөгөөд “Ирэх даваа гаригт (өнөөдөр) болох цугларалтад бэлтгэх ажил өмнө хүлээж байна” гэсэн нь ярилцлагаа дуусгав гэж санаа байлаа. Зэвсэгт хүчиндээ хайртай, ахлагчийн албаараа бахархдаг, хийж бүтээхийн хүсэл мөрөөдөл дүүрэн нэгэн эрхмийг олж уулзсандаа олзуурхсан сурвалжлагч би бээр ч баяртайгаар ангийн хашаанаас гарч одов.

Ахмад Д.БОЛОР

ЦЭРГИЙН ЧУУЛГААР...



Монгол түмний уламжлалт хугацаат цэргийн алба хаагчид баяр цагаан сарыг тохиолдуулан “Амар мэндийн илгээмж”-ийг аав, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн ээж, амраг хайрт, анд нөхдөдөө

зориулан бичиж, илгээлээ. Захиа нь хүмүүсийн хоорондын харилцааны нэг хэлбэр бөгөөд дотоод сэтгэл дэх уран яруу үгийн илэрхийлэл болдгоороо онцлог билээ.

Байлдагч Э.Цэрэндаш, Б.Батжаргал нарын ар гэртээ бичсэн захидлаас... Цэргийн хуарандаа ижилдэн дассан Цэргийн андуудтайгаа мөр нийлүүлэн Цэргийн албаа нэр төртэй хаагаад Цэргээс хүү нь халагдаад очно оо Төрийн сүлдээ тэргүүндээ залсан Түүхэн домогт 015 дугаар ангийн байлдагч би Түүртэлгүй албаа сайн хаагаад Төрсөн нутагтаа халагдаад очно оо

ХАЙРТАЙ ШҮҮ ЭЭЖЭЭ
Дэслэгч Ө.ЦЭРЭНЛХАМ

ҮБХИС-ИЙН

БАГШ, СОНСОГЧИД ЦУСАА ХАНДИВЛАВ



ҮБХИС-ийн сонсогч, оюутнууд Цус судлалын үндэсний төвөөс зарлан явуулж буй “Бусдадаа амьдрал бэлэглэе” сайн үйлсийн аянд оролцож, цусаа хандивлажээ. Тус төвийнхөн “Ирээдүйд Зэвсэгт хүчний эгнээнд элсэж, өнгөлөн алхах залуус та бүхний сайн үйлсэд талархал илэрхийлье.

Та бүхний хандивласан цус 240 хүний амь насыг аварч байна” хэмээн уламжилжээ. Сүүлийн жилүүдэд Ковид-19 цар тахлын улмаас цусаа хандивлах иргэдийн тоо буурч, эмнэлгүүд дэх цусны нөөц эрс багасаад байгаа юм.

ҮБХИС